



# “БЭНД САУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛАГА

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө-13,  
Утас/Факс: 976-70114810, 7011 4810

Огноо: 2020.02.07

Ulaanbaatar city, Khan-Uul district  
Chinggis avenue-13  
Phone/Fax: 976-70114810, 7011 4810

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МОНГЕО” ХК-ИЙН  
ЗАХИРАЛ ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Бид “МОНГЕО” ХК (цаашид “Компани”гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бodoх бүртгэлийн бодлогуудад аudit хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний тайлантууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл(НБЭЗОУС3)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУС3-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

### Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, тууштай ажиллуулах, нягтлан бodoх бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бodoх бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

### **Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөвчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооплыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

### **Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

### **Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаал, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын тогтоолоор баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцэж байна.

ЗАХИРАЛ

Д. ДАШХОРЛОО